

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

---

2010 оны 08 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 225

Улаанбаатар хот

Г “Зээлийн батлан даалтын үйлчилгээний”  
зохицуулалтын түр журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Зээлийн батлан даалтын үйлчилгээний зохицуулалтын түр журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## **ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮР ЖУРАМ**

### **Нэг . Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь зээлийн барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зориулалтаар зээлийн батлан даалтын үйлчилгээ эрхлэх банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээс сэргийлэх, хяналт тавихад оршино.

1.2. Зээлийн батлан даалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбогдсон харилцааг энэ журам болон Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-аар зохицуулна.

### **Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт**

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “зээлийн батлан даалтын үйлчилгээ” гэж Хорооноос зээлийн батлан даалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан банк бус санхүүгийн байгууллага өөрийн хөрөнгөөр жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн банк, санхүүгийн байгууллагаас авч буй зээлийн барьцаа хөрөнгийн дутагдалтай хэсэгт Иргэний хуулийн 458 дугаар зүйлд заасан батлан даалтын гэрээний дагуу үзүүлж буй үйлчилгээг;

2.1.2. “зээлийн батлан даагч” гэж Хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр зээлийн батлан даалтын үйлчилгээ эрхлэх банк бус санхүүгийн байгууллагыг;

2.1.3. “үүрэг гүйцэтгүүлэгч” гэж зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцаанд оролцогч, Монгол улсад бүртгэлтэй банк, санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоог;

2.1.4. “үүрэг гүйцэтгэгч” гэж үүрэг гүйцэтгүүлэгчийн олгох зээлийн үйлчилгээнд хамрагдаж, барьцаа хөрөнгийн дутагдалтай хэсгээрээ зээлийн батлан даалтын үйлчилгээг хүртэж буй Монгол улсын жижиг, дунд үйлдвэр эрхлэгч этгээдийг;

2.1.5. “зээлийн батлан даалтын гэрээ” гэж Иргэний хуулийн 45 дугаар бүлэгт заасан зээлийн батлан даагч, үүрэг гүйцэтгүүлэгчийн хооронд бичгээр үйлдэж, баталгаажуулсан хэлцлийг.

### **Гурав. Зээлийн батлан даалтын үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлага**

3.1. Зээлийн батлан даалтын үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргагчид дараах шаардлагыг хангасан байна:

3.1.1. дүрмийн сан дахь зээлийн батлан даалтын үйлчилгээний эх үүсвэрийн мөнгөн хөрөнгийн хэмжээ нь 3,000,000,000 /гурван тэрбум/ төгрөгөөс доошгүй байх;

3.1.2. зээлийн батлан даалтын үйлчилгээ эрхлэхээр банк бус санхүүгийн байгууллага байгуулан тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргагч нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Хорооны 2008 оны 186

дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”, энэхүү журамд заасан шаардлагыг хангасан баримт бичгүүдийг Хороонд тус тус ирүүлсэн байх;

3.1.3. холбогдох хууль тогтоомж, энэ журам болон зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан дотооддоо мөрдөхөөр батлан гаргасан журам, зааварт нийцүүлэн үүрэг гүйцэтгэгчтэй байгуулбал зохих зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх гэрээний баталсан загварыг ирүүлсэн байх;

3.1.4. Хорооноос баталсан холбогдох заавар, журамд заасан болон бусад нэмэлт шаардлагыг хангасан байх.

### **Дөрөв. Зээлийн батлан даагчийн эрх, үүрэг**

4.1. Зээлийн батлан даагч нь дараах эрхтэй:

4.1.1. үүрэг гүйцэтгэгчид зээлийн батлан даалт гаргах шийдвэр гаргахын өмнө түүний санхүү, удирдлагын чадавхи, бизнес төлөвлөгөө болон бусад шаардлагатай мэдээлэлтэй танилцаж, магадлан шинжилгээ хийх;

4.1.2. зээлийн батлан даалтын болон зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулагдсан өдрөөс хойш үүрэг гүйцэтгэгчийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох бүртгэл, тайлан, мэдээг шаардах;

4.1.3. зээлийн батлан даалтын болон зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулагдсан өдрөөс хойш үүрэг гүйцэтгүүлэгчээс сард нэгээс доошгүй удаа үүрэг гүйцэтгэгчийн зээлийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, хэрэгжилтийн талаар мэдээлэл авах;

4.1.4. шаардлагатай гэж үзвэл үүрэг гүйцэтгэгчийг тухайн нэр төрлийн даатгалын үйлчилгээнд хамрагдсан байхыг шаардах;

4.1.5. үүрэг гүйцэтгүүлэгчээс батлан даагчид шаардлага гаргавал үүрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг гаргаж болох бүх татгалзлыг гаргах;

4.1.6. өөрийн журмаар тогтоосны дагуу үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан үүрэг гүйцэтгэгчээс батлан даалт гаргах үед зээлийн батлан даалтын үйлчилгээний шимтгэл болон зээлийн батлан даалтын үлдэгдэл дүнд ногдуулан авах зээлийн батлан даалтын жил бүрийн хураамжийг авах;

4.1.7. зээлийн батлан даалтын болон зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргах;

4.1.8. үүрэг гүйцэтгэгчийн зээлийн батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан зээлийг барагдуулах зорилгоор бусдад худалдах, түүнтэй холбогдсон хуулиар тогтоосон бусад арга хэмжээнд оролцох;

4.1.9. хууль тогтоомжоор заасан бусад.

4.2. Зээлийн батлан даагч нь дараах үүрэгтэй:

4.2.1. Хороонд жил бүр төвлөрүүлбэл зохих зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны 2009 оны 267 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тооцох журам”-д заасан төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээний хөлстэй адилтган тогтоосон хугацаанд бүрэн төвлөрүүлэх;

4.2.2. нийт зээлийн батлан даалтын хэмжээ нь зээлийн батлан даагчийн өөрийн хөрөнгийг 5 дахин нэмэгдүүлснээс ихгүй байх;

4.2.3. нэг этгээдэд гаргасан зээлийн батлан даалтын хэмжээ нь үүрэг гүйцэтгэгчийн үүрэг гүйцэтгүүлэгчээс авах тухайн зээлийн 80 хувь буюу зээлийн батлан даагчийн өөрийн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байх;

4.2.4. үүрэг гүйцэтгүүлэгчтэй батлан даалтын гэрээ, үүрэг гүйцэтгэгч тус бүртэй зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх гэрээг тус тус байгуулсан байх;

4.2.5. зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан дотооддоо мөрдөхөөр батлан гаргасан журам, зааварт өөрчлөлт орсон тухай бүр Хороонд ирүүлэх;

4.2.6. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллах;

4.2.7. жилийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулан дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлж, баталгаажуулсан санхүүгийн тайланг Хороонд ирүүлэх;

4.2.8. сар, улирлын санхүүгийн болон Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан, мэдээг дараа сарын 10-ны өдрийн дотор ирүүлэх;

4.2.9. зээлийн батлан даалтын үйлчилгээнээс бий болж болзошгүй эрсдэлийг удирдах, хяналт тавих зүй зохистой тогтолцоог бүрдүүлэх;

4.2.10. зээлийн батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан үүрэг гүйцэтгэгч тус бүр дээр /хуулийн этгээд бол тэдгээрийн дүрэм, зээлийн батлан даалтын гэрээ болон зээлийн батлан даалтын үйлчилгээтэй холбоотой бусад баримт бичиг г.м/ хувийн хэрэг нээж хөтлөх.

#### **Тав. Зээлийн батлан даалтын болон зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах**

5.1. Зээлийн батлан даалтын болон зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулж, нотариатаар гэрчлүүлсэн байна.

5.2. Зээлийн батлан даалтын болон зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх гэрээнд дараах зүйлийг зайлшгүй тусгасан байна:

5.2.1. гэрээнд оролцогч талуудын нэр, улсын бүртгэл, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, хаяг, холбоо барих утасны дугаар;

5.2.2. зээлийн батлан даалтын нийт хэмжээ, эргэн төлөх хуваарь;

5.2.3. талуудын эрх, үүрэг, хариуцлага;

5.2.4. эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаарх талуудын үүрэг, хариуцлага;

5.2.5. гэрээний хэрэгжилтэд хяналт тавих нөхцөл, шаардлага;

5.2.6. гэрээг дүгнэх, үүсэх үр дагавар, зохицуулалт;

5.2.7. гэрээ дуусгавар болгох нөхцөл.

5.3. Зээлийн батлан даалтын гэрээнд энэ журмын 5.2-т зааснаас гадна дараах зүйлийг зайлшгүй нэмж тусгасан байна:

5.3.1. гэрээг байгуулсны дараа үүрэг гүйцэтгэгчийн хийсэн хэлцлээс үүсэх үр дагаврыг батлан даагч хариуцахгүй;

5.3.2. үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд түүний өмнөөс батлан даагчийн хүлээх хариуцлагын дээд хэмжээ;

5.3.3. үүрэг гүйцэтгэгч үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ тухай батлан даагчид мэдэгдэх;

5.3.4. батлан даагч шаардсан бол үүрэг гүйцэтгүүлэгч үндсэн гэрээгээр үүрэг гүйцэтгэгчийн хүлээх үүргийн талаар түүнд үнэн зөв мэдээлэл өгөх;

5.3.5. батлан даалтын гэрээг тодорхой хугацаа заалгүй хийсэн бол батлан даагч нь гэрээг дуусгавар болохоос 3-аас доошгүй сарын өмнө мэдэгдэх;

5.3.6. батлан даагч нэг талын санаачилгаар батлан даалтын гэрээг цуцалсан бол ийнхүү цуцлахаас өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх;

5.3.7. энэ журмын 4.1.3, 4.1.5, 4.1.7-4.1.10-д заасан эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах заалт.

5.4. Зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх гэрээнд энэ журмын 5.2-г зааснаас гадна дараах заалтуудыг зайлшгүй нэмж тусгасан байна:

5.4.1. батлан даалтын гэрээг байгуулсны дараа үүрэг гүйцэтгэгчийн хийсэн хэлцлээс үүсэх үр дагаврыг батлан даагч хариуцахгүй;

5.4.2. зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх гэрээнд энэ журмын 4.1.2, 4.1.4, 4.1.6-4.1.10-д заасан эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах заалт.

### **Зургаа. Хориглох зүйл**

6.1. Зээлийн батлан даагч дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

6.1.1. дүрмийн сан дахь зээлийн батлан даалтын үйлчилгээний эх үүсвэрийн мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах, хадгаламжийн дансаас бусад хэлбэрээр байршуулах;

6.1.2. зээлийн батлан даалтын үйлчилгээний талаар худал, ташаа мэдээ мэдээлэл хийх, зар сурталчилгаа явуулах;

6.1.3. санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдаагүй мөнгөн хөрөнгөөр зээлийн батлан даалтын үйлчилгээнд эх үүсвэр болгон ашиглах;

6.1.4. Хорооноос зөвшөөрөөгүй бусад үйл ажиллагаа эрхлэх.

### **Долоо. Хяналт, хариуцлага**

7.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Хороо хяналт тавина.

7.2. Холбогдох хууль тогтоомж, заавар, журмыг зөрчсөн, цаашид үйл ажиллагаанд нь эрсдэл үүсч болзошгүй гэж үзвэл Хороо дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ:

7.2.1. өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх;

7.2.2. зээлийн батлан даалт нэмж гаргахыг зогсоох, хязгаарлах;

7.2.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх.

...ooOoo...